

# 2024

---

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН



## АГУУЛГА

### Бидний тухай

#### Үйл ажиллагааны хураангуй

Онцлох үйл явдал  
Санхүү байдлын тайлан, Орлого үр дүнгийн тайлан  
Гүйцэтгэх дэд удирдлагын баг  
АПУ Групп компанийн бүтэц  
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт  
Эрсдэлийн удирдлага

#### Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн хурал  
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц  
Төлөөлөн Удирдах зөвлөл  
Ногдол ашгийн мэдээлэл  
Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ  
Хувьцааны арилжааны мэдээлэл

#### Тогтвортой хөгжил

Байгаль орчин  
Нийгэм  
Хүн менежмент  
Соёл, хамтын ажиллагаа

## УРИА ҮГ

ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ  
ALWAYS FORWARD



## ЭРХЭМ ЗОРИЛГО

ШИНЭ САНААЧИЛГА, БҮТЭЭХ ТЭМҮҮЛЛЭЭР УРЛАЖ БУЙ БҮХЭНДЭЭ  
ҮРГЭЛЖ СЭТГЭЛЭЭ ШИНГЭЭНЭ.

## АЛСЫН ХАРАА

ДЭЛХИЙД ТАНИГДАХ ЭРХЭМ МОНГОЛ ХҮМҮҮНИЙ ОЮУН ЧАДВАР, УР  
УХААН, ШИНЭЧЛЭЛ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УНДАРГА БАЙА.

## ҮНЭТ ЗҮЙЛС



## ДАДАЛ ХЭВШИЛ

ЭРЭЛ, ХАЙГУУЛЧ  
СЭТГЭЭ

Тасралтгүй  
шинийг  
эрэлхийлж,  
хуваалцаж,  
суралцаж,  
туршъя.

ХАМТДАА  
ЯЛЪЯ

Чанарыг  
эрхэмлэж  
ялалтын  
сэтгэлгээгээр  
урагшилья.

ИННОВАЦИЛАГ  
АЖИЛЛАЯ

Уламжлалаа  
хүндэлж,  
шинийг  
бүтээе.

ХҮНДЛЭН  
ЭРХЭМЛЭЭ

Хүн байхыг  
чухалчилж,  
сайн сайхныг  
түгээе.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

### Борлуулалтын тоо хэмжээ

сая.литр



### Цэвэр борлуулалтын орлого

тэрбум.төгрөг



### Үйл ажиллагааны ашиг

тэрбум.төгрөг



### Цэвэр ашиг

тэрбум.төгрөг



### Хөрөнгө оруулалт

тэрбум.төгрөг



### Татвар төлөлт

тэрбум.төгрөг




### Бүтээгдэхүүний төрөл

Нэр төрлийн тоо



2023.VI



2024.VI

### Ажилтны тоо



2023.VI



2024.VI



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

### ХАРИЛЦАГЧ, ХЭРЭГЛЭГЧ НАРТАА ЗОРИУЛСАН ЦОО ШИНЭЛЭГ "ALWAYS FORWARD TOGETHER: EXPERIENCE SHOW"

Үндэсний үйлдвэрлэл, хамтын ажиллагааг эрхэмлэж ирсэн бид 100 жилийн ойгоо тохиолдуулан хамт олон, харилцагч, хамтрагч нартаа зориулж цоо шинэ арга хэмжээг зохион байгууллаа. Энэ арга хэмжээ нь цоо шинэ мэдрэмжийг төрүүлэхээс гадна бүтээгдэхүүн хэрхэн бүтэж буй үйл явц, түүхий эд татан авалт, брэндийн утга учир, үнэ цэн, түүх, уламжлал, инновац гэх мэт бүхий л шинэ шинэлэг туршлага, мэдээллийг нэг дор хүлээн авах боломж олгосноороо ач холбогдолтой үйл ажиллагаа болж өндөрлөлөө.

АПУ компани нь газар тариалан, мал аж ахуй, тээвэр ложистик, худалдаа, үйлчилгээний зэрэг салбаруудад үйл ажиллагаа явуулж буй 15 мянга гаруй хамтрагч, ханган нийлүүлэгч, харилцагчид, 28 мянга гаруй хувьцаа эзэмшигчидтэйгээ хамт улсынхаа хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж байна. Үнэ цэнийг хамтдаа бүтээлцэж ирсэн эрхэм хамт олон, харилцагч, түншүүддээ зориулан салбарын шинэ жишгийг хамтдаа тодорхойлж, үйл ажиллагааны талаарх бүхий л талын мэдээллийг хүргэн, салбарын ирээдүйн чиг хандлагын талаар мэдлэг түгээж, өөрийн биеэр туршиж үзэх, танилцах боломжийг олгосноороо онцлог арга хэмжээ болж өнгөрлөө. АПУ компани Олон улсын түвшний өвөрмөц брэндүүдийг бүтээж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн инновацийг тасралтгүй хийж, дэлхийд үнэлэгдэх үнэ цэн бүтээж буй харилцагч, хамтрагчидтайгаа шинэ санаачилгаар хамтдаа урагшилж, шинийг эрэлхийлэн мэдлэг туршлагаа хуваалцсаар байна.





ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



“PLAYTIME FESTIVAL 2024” НААДМЫН СТРАТЕГИЙН ТҮНШ - АПУ КОМПАНИ

Түүхэн 100 жилийн ойн баяртаа зориулан “Playtime Festival 2024” амьд хөгжмийн наадамд албан ёсны стратегийн түнш байгууллагаар залуусын соёлтой хэрэглээг дэмжин 16 дахь жилдээ хамтран ажиллалаа. АПУ компани орчин үеийн хөгжмийн урлаг, соёлоор дамжуулан тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилготойгоор энэ жилийн амьд хөгжмийн наадамд шинэ брэнд, шинэ агуулга, шинэ бүхнээр манлайлан оролцсон юм. Наадмын стратегийн түншийн хувьд нараар эрчимжсэн “APULSE Zone”-ийг тохижуулан хамгийн сүүлийн үеийн технологи бүхий хавтангуудыг байршуулан EcoFlow ухаалаг нарны эрчим хүчний зөөврийн цахилгаан үүсгүүр ашиглаж нүүрстөрөгчийн хийн ялгарлаа бууруулахад хувь нэмрээ оруулан ажилласан юм. Түүнчлэн “Өнгө нэм” ТББ-тай хамтран APULSE Zone дахь хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж, наадамд оролцогч залууст мэдлэг ойлголт өгөх ажлыг сонирхолтой байдлаар хүргэн залуусын дунд зөв хандлага төлөвшүүлэхэд анхааран ажиллав. APULSE Zone нийт 197.44кг CO<sub>2</sub>, 86.41кг нүүрс, 11ш ой мод хэмнэн ажиллаж 252.2 кВт эрчим хүчийг үйлдвэрлэж хэрэглээндээ ашиглалаа. Ингэснээр байгаль дэлхийдээ ээлтэй байдлаар арга хэмжээг зохион байгуулахын зэрэгцээ, залуусын хариуцлагатай, соёлтой хэрэглээг бий болгох, олон нийтийн хог хаягдлын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, ангилах, дахин боловсруулах дадал, тогтолцоог бий болгох зорилт тавин ажиллаж байна.

“Playtime Festival 2024”-ийн APULSE Zone дахь онцлох арга хэмжээг дурдвал Шунхлай группийн ерөнхийлөгч П.Батсайхан захирал “Fireside Talk” яриа өрнүүлэн, Sound Meditation буюу бүх хүртэхүйн хөгжимт бясалгал, Big Sistas Comedy, Өглөөний сэргээш дасгал гэх мэт сонирхолтой хөтөлбөрөөр дүүрэн байж, залуусын соёлтой хэрэглээг дэмжиж, хариуцлагатай зохистой байдлыг уриалан ажиллалаа.





## ЭКСПОРТЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### ОЛОН УЛСЫН "PROWEIN 2024" ҮЗЭСГЭЛЭНД ЭХ ОРНОО ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОВ

Гучин жилийн түүхтэй дэлхийн хамгийн том шингэн хүнсний олон улсын үзэсгэлэн болох "Prowein 2024" арга хэмжээнд Chinggis Khan брэндээр АПУ компани Монгол улсаас анх удаа амжилттай оролцлоо. Энэ жил Prowein үзэсгэлэнд 65 улсын 5400 компани оролцож, 135 улсын 50 мянга гаруй зочид хүрэлцэн ирж сонирхсон байна. Энэхүү үзэсгэлэн нь хэрэглэгч харилцагч нарыг холбосон хамгийн том гүүр гэж олон улсын хэмжээнд үздэг билээ. Тус үзэсгэлэнд Chinggis Khan, Soyombo, Chinggis Grand Khan, Eden брэндээ дэлхийн хэрэглэгч нарт танилцуулж, экспортын үйл ажиллагаагаа шинэ түвшинд гаргасан үйл явдал боллоо. Бид үндэсний брэнд бүтээгдэхүүнээ олон улсад таниулах Монгол улсаа дэлхийд сурталчлах ажлаа үе шаттайгаар өргөжүүлэн ажилласаар байна.

### БНСУ-ЫН СӨҮЛ ХОТОД БОЛСОН "SEOUL BAR & SPIRIT SHOW" ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦЛОО

Салбарын шинэ соёл, тухайн жилийн трендийг тодорхойлж, үйлдвэрлэгч, харилцагч, хэрэглэгчдийг холбодгоороо онцлогтой "Seoul Bar & Spirit Show"-нд оролцлоо. Энэ үзэсгэлэнгээр Эден брэндээ Солонгосын хэрэглэгч нартаа танилцуулж, амт чанар, орц найрлага, брэндийн онцлогоо тайлбарлан таниуллаа. Дэвшилтэт технологи, инновац, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүний чанар, харилцагч хэрэглэгчидтэйгээ буй болгосон хамтын үнэ цэн, брэнд бүтээгдэхүүнээрээ дамжуулан эх орныхоо соёл, өв уламжлалыг олон улсад түгээн ажиллаж байна.



### TFWA – АЗИ НОМХОН ДАЛАЙН ҮЗЭСГЭЛЭН

TFWA буюу олон улсын татваргүй болон аялал жуулчлалын жижиглэн худалдааны хамгийн том холбооны Сингапур улсад болсон Ази Номхон далайн үзэсгэлэнд амжилттай оролцлоо. Өндөр зэрэглэлийн 300 гаруй брэнд, 3,000 гаруй зочидтой тус үйл ажиллагаанд АПУ компани холбооны гишүүнчлэлээ дахин сэргээж олон улсын хамтын ажиллагаа, цар хүрээгээ тэлэх зорилтоо хэрэгжүүлэн ажилласаар байна.



## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Балансын бүтцэд орсон өөрчлөлтүүд:

Харилцагч нараа дэмжих, экспортын үйл ажиллагааг тэлэх бодлогыг үргэлжлүүлэн идэвхтэй хэрэгжүүлснээр авлагын дүн нэмэгдсэн ба бараа материалын нөөцийн менежментийг сайжруулснаар нөөцийг зохсистой хэмжээнд бууруулсан, хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотойгоор эргэлтийн хөрөнгө өнгөрсөн оны сүүлчтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байлаа.

Хөдөө аж ахуйн салбар болон сүүн сүүн бүтээгдэхүүнийг дэмжсэн үнэ цэн авчрах төслүүдийг хэрэгжүүлснээр хөрөнгө оруулалтын урьдчилгаа өссөн, холбогдох урт хугацаат гадаад санхүүжилтийн зээлийн хэмжээ өссөн байна.

		2023 II улирал Аудитлагдаагүй	2024 II улирал Аудитлагдаагүй
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	433,663.37	516,443.42
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	531,350.18	553,987.11
<b>Нийт хөрөнгө</b>	сая.төг	<b>965,013.55</b>	<b>1,070,430.53</b>
Өр төлбөр	сая.төг	307,075.35	323,622.69
Эздийн өмч	сая.төг	657,938.20	741,807.84
<b>Нийт өр төлбөр ба Эздийн өмч</b>	сая.төг	<b>965,013.55</b>	<b>1,070,430.53</b>

## ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Орлого үр дүн:

2024 оны 2-р улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад АПУ Групп компанийн цэвэр борлуулалтын орлого 25%-иар өссөн ба татварын дараах цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеийнхээс 51%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Борлуулалтын орлогын өсөлт нь шинэ төрлийн сүү сүүн бүтээгдэхүүн болон ус ундааны төрлүүдийг нэмэгдүүлсэн, мөн Дижитал концепт ХХК болоод Экспортын борлуулалтын өсөлтөөс хамаарсан.

Мөн Монгол үндэсний уламжлал, орчин үеийн инновацыг хослуулсан шинэлэг чанартай брэнд бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, байгууллагын хүн төвтэй бодлогын хүрээнд ажилчдын цалин хангамж, тасралтгүй хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хийгдэж буй хүн нийгэмд хандсан хөтөлбөрүүд нь удирдлага маркетингийн зардлуудыг өсгөхөд гол нөлөө үзүүлжээ.

		2023 II улирал Аудитлагдаагүй	2024 II улирал Аудитлагдаагүй
Борлуулалтын орлого (цэвэр)	сая.төг	517,884.79	649,401.73
Борлуулалтын өртөг	сая.төг	291,330.65	336,965.18
<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	сая.төг	<b>226,554.13</b>	<b>312,436.56</b>
Үйл ажиллагааны зардал	сая.төг	137,074.99	173,511.08
<b>Үйл ажиллагааны ашиг</b>	сая.төг	<b>89,479.14</b>	<b>138,925.47</b>
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	сая.төг	1,647.80	716.88
<b>Татварын өмнөх ашиг</b>	сая.төг	<b>91,126.94</b>	<b>139,642.35</b>
Орлогын албан татварын зардал	сая.төг	19,454.75	31,743.14
<b>Татварын дараахь ашиг (алдагдал)</b>	сая.төг	<b>71,672.19</b>	<b>107,899.24</b>
		2023 II улирал	2024 II улирал
Үйл ажиллагааны маржин		17%	21%
Цэвэр ашгийн маржин		14%	17%



ГҮЙЦЭТГЭХ ДЭД  
УДИРДЛАГЫН БАГ



Цэвээнжавын  
**ЭРДЭНЭБИЛЭГ**  
Гүйцэтгэх захирал



Добрев  
**НИКОЛАЙ**  
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа  
эрхэлсэн захирал



Дандарова  
**АРИУНА**  
Глобал худалдаа  
эрхэлсэн захирал



Гончигийн  
**ЭНХБИЛЭГ**  
Санхүү эрхэлсэн захирал,  
Төслийн удирдлагын  
захирал



Батсайханы  
**ЦАЦРАЛ**  
Борлуулалт, маркетинг  
эрхэлсэн захирал




Галсумъяагийн  
**БАЯРМАГНАЙ**  
АПУ Дэйри ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал



Жаргалсайханы  
**ИЧИНХОРЛОО**  
Захиргаа, Хүний нөөц  
эрхэлсэн захирал

## АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ

Тайлант хугацаанд АПУ Групп компанийн бүтцэд өөрчлөлт гараагүй.



## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

### ДЭЛХИЙД ҮНЭЛЭГДСЭН ЧАНАР – MONDE SELECTION

Олон улсын чанар, стандартыг тодорхойлогч “Monde Selection” хүрээлэнгээс жил бүр дэлхийн үйлдвэрлэгчдийн хүнс, ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүнд үнэлгээ хийж шилдгүүдийг шалгаруулдаг уламжлалтай. Тус наадамд Тэрэлж Сэлэнгэ брэнд “GOLD WINNING AWARDS”, Агар, Нийслэл Super Lite, Оргилуун \тоортой\ зэргээр Gold award, мөн коктейлийн төрөлд Ooze Granberry and Vodka, шар айргийн төрөлд Алтан говь брэнд Silver award хүртлээ. Ингэснээр Европын болоод дэлхийн шингэн хүнсний зах зээлийн хамгийн өндөр чанар, стандартыг хангасан бүтээгдэхүүнүүдээр нэрлэгдсэн юм.



### АПУ 100

АПУ ХК-ийн 100-н жилийн хүрээнд шар айраг болон ундааны гол брэндүүд дээр “Playtime” болон “Paris Olympics 2024” зэрэг томоохон үйл ажиллагаануудтай хамтран “Боргио” болон “Нийслэл” брэндүүд дээр “limited edition” савлагаануудыг хөгжүүлэн гаргав. Үндэсний брэнд Тэрэлж ба Сэлэнгэ ундаануудын савлагааг шинэчлэн мөн шинэ төрлийг зах зээлд гаргалаа.

### ШИНЭ ТРЕНД – БАГА ХАТУУЛАГ

Хатуулаг багатай бүтээгдэхүүний хэрэглээний шинэ хандлагыг хэрэглэгчдэд ойртуулан эх орны шилмэл улаан буудайн Arkhi Bluemark брэндийг зах зээлд танилцуулав. Velvet брэндийг бүрэн шинэчлэн, шинэлэг амт бүхий Velvet Nuit төрлийг зах зээлд гаргав. Орчин цагийн залуусын хэрэглээний хүчтэй хэв маягийг шингээн “W/” брэндийг зах зээлд танилцууллаа.

### ИННОВАЦИ – ШИНЭЧЛЭЛ

Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих чихэргүй хэрэглээний шинэ сонголт болох “Оргилуун Zero” брэндийн төрлийг нэмэгдүүлж, үндэсний ундааны брэнд болох Тэрэлж брэндийн чихэргүй, байгалийн гаралтай амт оруулагч бүхий “Тэрэлж Zero” төрлийг зах зээлд шинээр танилцууллаа. Мөн чихэргүй, бага калори бүхий согтууруулах ундааны шинэ төрөл “Hard seltzer”-г шинээр танилцуулан “Eve by Eden” брэндийг хөгжүүлэн гаргав. Түүнчлэн хэрэглэхэд хялбар Frutta брэндийг жижиг савлагаатайгаар худалдаанд гаргалаа.

### ЭРҮҮЛ – ШИНЭЛЭГ

АПУ компани Монгол хүний сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэхийг зорин хэрэглэгчдийн хүсэл хэрэгцээнд нийцсэн шинэ брэнд, шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлэн ажилласаар байна. 2024 он гарсаар найрлагандаа онцгой орц болох саффрон цэцгийг агуулж, ванил болон амтат гуан амтаар баяжуулсан өвөрмөц, тансаг амт бүхий **Healthy milk**, бага насны хүүхдүүдийн сахарын хэрэглээг бууруулах, амин дэмээр байжуулсан хэрэглээнд нийцэх савлагаа бүхий **Baby shark** брэндийг худалдаанд гаргалаа.





## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

АПУ ХК нь тогтвортой хөгжлийн тулгуур багана болох байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй засаглалыг бэхжүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна. Ялангуяа аливаа хийгдэж буй төсөл хөтөлбөр, томоохон хөрөнгө оруулалтын шийдвэрүүдээ тогтвортой хөгжлийн зарчим, чиг хандлагад нийцүүлэн шийдсээр байна. Тухайлбал: Сүүн сүүн бүтээгдэхүүн нийлүүлэгч малчин өрхүүдийг сургалтаар хангах үүгээр дамжуулан хөрсний үржил шимт байдал, байгаль экологийн тэнцвэрийг хангахад чиглэх, мөн үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэх байгууламж барих тал дээр гадны санхүүжилт татахаар эрэлхийлж байна. Ингэснээр эрсдэлийн удирдлагыг илүү өргөн хүрээнд авч хэрэгжүүлэх боломжтойн зэрэгцээ аливаа болзошгүй эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдлыг урт хугацаандаа оновчтой удирдахад туслах юм.

Мөн манай салбарын болон компанийн үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар нөлөөлөх томоохон эрсдэлүүдийг бид тооцоолж тодорхойлсон ба эдгээрээс хамгийн өндөр ач холбогдолтой гэдгээр нь голлох 4 эрсдэлийг онцоллоо. Үүнд байгаль цаг уурын гэнэтийн өөрчлөлт, давагдашгүй хүчин зүйл, эдийн засгийн орчны

тогтворгүй байдал, нийлүүлэлтийн гинжин хэлхээний хүндрэлүүд, болон хэрэглээний шилжилт, хэв маягтай холбоотой нөлөөллийг хамруулав. Эдгээрээс урьдчилан сэргийлэх, хамгийн бага эрсдэлийн түвшинд оновчтой удирдахын тулд шаардлагатай хариу арга хэмжээнүүдийг тодорхойлж нэгдсэн удирдлага зохион байгуулалтын дагуу шат шатандаа анхааран ажилласаар байна. Нэн ялангуяа урт болон богино хугацааны санхүүг төлөвлөх, процессыг сайжруулахад чиглэсэн санал санаачилгуудыг дэмжих, үйлдвэрлэл үйл ажиллагааны тасалдалгүй байдлыг хангах, хөрөнгө оруулагч, ажилтан, хэрэглэгч нийлүүлэгчид болох компанийн бүхий л оролцогч талуудын сэтгэл ханамжийг дээшлүүлж үнэ цэнийг түгээхэд төвлөрлөө.

Үүний зэрэгцээ дотоод эх үүсвэртэй эрсдэлүүдээ ARM буюу эрсдэлийн удирдлагын программаар дамжуулан тодорхойлж, үнэлэн, дүн шинжилгээ хийдэг. Улмаар бусад алба нэгжүүдийн оролцоотойгоор зохимжит түвшинд эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээний төлөвлөгөө болон ажлын гүйцэтгэлд нь мөшгөлт хийж учирч болох эрсдэлийг удирдан ажиллаж байна.

## ГАДААД ХУЧИН ЗҮЙЛСИЙН НӨЛӨӨЛӨЛ БА ТОМООХОН ЭРСДЭЛҮҮД



## ТАЙЛБАР

EL NINO (Номхон далайн гадаргуу дахь температур өөрчлөгдөж халснаар дэлхийн цаг уурын эрс тэс нөхцөл байдал үүсэхийг хэлнэ.) үзэгдлийн нөлөөгөөр зарим бүс нутагт их хэмжээний хур тунадас, үерийн аюул дагуулж байгаа бол өөр нэг хэсэгт ган зуд болох эрсдэлийг учруулснаар хөрсний гулгалт, элэгдэл үүсэх, гал түймэр гарах зэргээр экосистемийн олон талт байдалд сөргөөр нөлөөлсөөр байна. Энэ нь компани тогтвортой хөгжилд чиглэсэн арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлэх, байгальд ээлтэй бодлого, төлөвлөлт хийх шаардлагатайг харуулж байна.

Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотойгоор төсвийн зарцуулалт нэмэгдсэн нь оны сүүлээр бууралттай байсан инфляцын түвшин эргэн эрчимжихэд нөлөөлж байна. Мөн эхний хагас жилийн байдлаар гадаад худалдааны тэнцэл жилийн өмнөхөөсөө 23,6% буурсан. Цаашид импортын барааны нийт үнийн дүн экспортынхоос давсаар байвал чангараад байсан төгрөгийн ханш тогтвортой байдлаа алдах эрсдэлтэй. Ингэснээр компанийн үйл ажиллагааны нийт өртөг нэмэгдэх, гадаад гүйлгээний зардал өсөх, нөгөө талд хэрэглэгчийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Үйлдвэрлэлийн гол түүхий эд материал буюу хөдөө аж ахуйн бараа таваар болох элсэн чихэр, улаан буудай зэргийн ханш нь гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр савлах эрсдэлтэй байна. Үүнд нэн ялангуяа цаг уурын гэнэтийн өөрчлөлт, давагдашгүй хүчин зүйл, олон улсын худалдааны хориг, тарифын асуудлууд мөн тээвэр ложистик, үйлдвэрлэлийн салбар дахь ажиллах хүчний хомсдол үүссэнтэй холбоотой юм.

Эрүүл мэндэд тустай, амин дэмээр баялаг ус, ундаа, сүү сүүн бүтээгдэхүүн болон архины агууламж багатай шингэн хүнсийг хэрэглэх сонирхол хэрэглэгчдийн дунд өсөн нэмэгдсээр байгаа нь үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнүүдээ оновчлох, илүү шинэлэг амт чанарыг эрэлхийлэх, хурдацтай өөрчлөгдөж буй хэв маягийг даган судалгаа шинжилгээг тогтмолоор яаралтай хийж, дотоодын шат дамжлага процессыг сайжруулж оновчлоход анхаарах шаардлагатайг харуулж байна.

## АРГА ХЭМЖЭЭ

Хямралын үеийн удирдлагыг хэрэгжүүлж, шаардлагатай нөөц төлөвлөлтийг хийж, төрийн агентлагуудтай үр дүнтэй хамтран ажиллах боломжийг эрэлхийлж байна. Мөн байгальд ээлтэй тээвэр түгээлтийг хийх, шилээ эргүүлэн татах, эко хөрөнгө оруулалтуудад онцгой анхаарч байгаа.

Эдийн засгийн савлагаат байдлыг урьдаас тооцоолон шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, боломжит санхүүгийн хэмнэлтийг хийх, богино болон урт хугацааны оновчтой хөрөнгө оруулалтыг хийж, санхүүжилт татах чиглэлд төвлөрөн ажиллаж байна.

Цөөн тооны нийлүүлэгчдээс зайлсхийж олон түншүүдтэй үр дүнтэй хэлэлцээр хийх, агуулахын болон бэлэн бүтээгдэхүүний төлөвлөлтийг сайжруулан, тээвэр түгээлтийн уян хатан нөхцөлийг эрэлхийлэх зэргээр эрсдэлийг бууруулахад чиглэн ажиллаж байна.

Дотооддоо процессын шат дамжлагыг үр дүнтэй бууруулж сайжруулах, автоматжуулалтыг дэмжих, бусад брендинг компаниуд, харилцагч, нийлүүлэгчидтэй үр ашигтай хамтран ажиллах, E-Commerce зах зээлийг ашиглахад анхааран ажиллаж байна.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2024 оны 04 сарын 30-ны өдрийн 14:00 – 15:30 цагийн хооронд 88.08%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав:

1. АПУ ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2023 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар сонгов:

Үүнд:

### Ердийн гишүүн


1. Пүрэвийн Батсайхан
2. Бүрэнтогтохын Батбаяр
3. Кеннет Чу
4. Сэн И-Ин
5. Батсайханы Гантиг
6. Баярцогтын Гомбо-Эрдэнэ

### Хараат бус гишүүн

1. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун
  2. Одончимэдийн Одбаяр
  3. Жигжидийн Үнэнбат
4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар батлав.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчид (2024 оны 04 сарын 12-ны өдрийн байдлаар)



Өнгөрөгч оны мөн үетэй харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Steppe Beverage KFT-ийн эзэмшлийн хувь 5%-аар буурч, бусад жижиг хувьцаа эзэмшигчдэд шилжжээ.



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ийн гишүүн Сергей Громов, Доржийн Миеэгомбо нар чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар ТУЗ-ийн дараах бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаатай сонгов.



**ПҮРЭВИЙН  
БАТСАЙХАН**  
ТУЗ-ийн ердийн гишүүн  
бөгөөд ТУЗ-ийн дарга

Инженер мэргэжилтэй  
Шунхлай групп ХХК-ийн  
Ерөнхийлөгч  
2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-  
ийн дарга  
Хувьцаа эзэмшил: 0.01%



**БҮРЭНТОГТОХЫН  
БАТБАЯР**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй  
Шунхлай групп ХХК-ийн Санхүү  
эрхэлсэн захирал  
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-  
ийн гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.01%



**КЕННЕТ ЧУ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Нягтлан бодогч, менежмент  
мэргэжилтэй  
Хайнекен Азия Пасифик компанийн  
Ази-Номхон далайн бүсийг  
хариуцсан Гүйцэтгэх захирал  
2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-  
ийн гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



**СЭН И-ИН**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хуульч мэргэжилтэй  
Хайнекен Азия Пасифик компанийн  
Ази-Номхон далайн бүсийн Хууль  
эрхзүй хариуцсан захирал  
2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-  
ийн гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



**БАТСАЙХАНЫ  
ГАНТИГ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Бизнесийн удирдлага, менежмент  
мэргэжилтэй  
Дижитал концепт ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал  
2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-  
ийн гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



**БАЯРЦОГТЫН  
ГОМБО-ЭРДЭНЭ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хэрэглээний математикч, эдийн засагч,  
санхүүч мэргэжилтэй  
Шунхлай холдинг ХХК-ийн Бизнес  
хөгжил хариуцсан захирал  
2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн  
гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



**ЁНДОН-ОЙДОВЫН  
ГЭРЭЛЧУЛУУН**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй  
Нээлттэй хот ТББ-ын үүсгэн  
байгуулагч  
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-  
ийн гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



**Одончимэдийн  
ОДБАЯР**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Багш, эрх зүйч мэргэжилтэй  
Ард даатгал ХК, Ард холдинг ХХК,  
Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн  
гишүүн  
2021 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн  
гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



**ЖИГЖИДИЙН  
ҮНЭНБАТ**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй  
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн  
гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



**ЧАДРААБАЛЫН  
АРИУНСАН**  
ТУЗ-ийн нарийн бичгийн  
дарга


Хувьцаа эзэмшил: 0.00%

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

ТУЗ-ийн 2024 оны 02 сарын 16-ны өдрийн 24/02 тоот тогтоолоор 2023 оны хоёрдугаар хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан нэгж хувьцаанд ₮44 (дөчин дөрвөн төгрөг)-ийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэн, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр (2024 оны 04 сарын 12-ны өдөр)-өөр тогтоож, ногдол ашгийг 2024 оны 12 сарын 31-ний өдрийн дотор төлөхөөр тогтоов. Тус ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-

аар зуучлуулан 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан ба таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгов.

### Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

АПУ ХК-ийн 2023 оны эцсийн компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайлангаар нийт 72 онооноос 70 оноо буюу 97%-аар үнэлснийг СЗХ-ны компанийн засаглал, комплайнсын хэлтсээс хянан баталгаажуулж, 67 оноо

буюу 93%-аар үнэлснээр “засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдлээ. Ийнхүү АПУ ХК нь кодексийн хэрэгжилтийн хянан баталгаажуулсан үнэлгээгээр нээлттэй хувьцаат компаниудаас 4-р байранд эрэмбэлэгдэж байна.

## ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ



АПУ ХК-ийн хувьцааны хаалтын ханш оны эхэнд ₮1,201 байсан бол хагас жилийн эцэст ₮984 болж буурсан. Тайлант хугацаанд хувьцааны хаалтын ханш дараах үзүүлэлттэй байв:

Их	1209
Бага	984
Дундаж	1080

Зах зээлийн үнэлгээ 2024 оны эхний хагас жилийн эцэст 1.05 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 23%-аар буурсан бөгөөд зах зээлийн үнэлгээгээр дөрөвдүгээр байранд орж байна.

АПУ ХК-ийн хувьцаа идэвхтэй арилжигдсан үнэт цааснаас үнийн дүнгийн эрэмбээр тавдугаарт, тоо ширхгийн эрэмбээр 17-д жагсжээ.



## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

### ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАНГАА ГАРГАЖ, “МОНГОЛ БАХАРХАЛ- 2030” СТРАТЕГИ БАТАЛЛАА

АПУ компани үйлдвэрлэл үйл ажиллагаандаа НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг шингээн ажиллаж ирсэн бөгөөд цаашид өөрийн баримтлах чиглэл бодлого, стратегийг хэлэлцэн боловсруулсан билээ. “Монгол бахархал – 2030” тогтвортой хөгжлийн таван хана бүхий стратегиа баталж, түүхэн зуун жилийн ололт амжилт, туршлага дээрээ үндэслэн дараагийн шинэ зуундаа байгаль орчин, нийгэм эдийн засагтаа эерэг нөлөөгөө эрчимжүүлж, хүн төвт бодлого, харилцагч түншүүдийн хамтын хөгжил дэвшлийг эрхэмлэн ажиллахаар зорьж байна. Ийнхүү АПУ компани тогтвортой хөгжлийн зорилтоо тодорхой болгож илүү ногоон, илүү нэгдсэн, илүү үр дүнд чиглэсэн алхамуудыг хийн ажиллахаар төлөвлөж байна. Түүнчлэн Тогтвортой хөгжлийн тайлан болон Байгаль Орчин, Нийгэм, Засаглалын (БОНЗ) тайлангаа бие даасан байдлаар 2 дахь жилдээ бэлтгэн гаргалаа.



## БАЙГАЛЬ ОРЧИН

### “ТУНГАЛАГ ТУУЛ – 2024” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

АПУ ХК-ийн хамт олон уламжлал болсон “Тунгалаг Туул” аянаа 2024 онд 4 дэх жилдээ үргэлжлүүлж 20 га орчим голын ай сав газрын хог хаягдлыг гурван байршилд цэвэрлэлээ. Улаанбаатар хотын Дунд гол болон Туул голын эрэг, Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь Хараа голын эргээр нийт 200 гаруй ажилтнууд хамтран цэвэрлэж, байгаль орчноо хог хаягдалгүй байлгах, эрүүл цэвэр орчныг бүрдүүлэн ажиллав. АПУ ХК-ийн “Тунгалаг Туул” аян нь хог хаягдлыг бууруулах томоохон тэргүүлэх зорилт дунд хамт олны оролцоог бэхжүүлэх гол зорилттой төдийгүй уламжлал болгон жил бүр зохион байгуулж байна.



### ДАХИН БОЛОВСРУУЛЦГААЯ-GO RECYCLE” АЯНТАЙ УРТ ХУГАЦААНДАА ХАМТРАН АЖИЛЛАНА

Тогтвортой хөгжлийн стратегийнхаа дагуу хүрээлэн буй орчин дахь ул мөрөө алхам бүртээ цогц байдлаар багасган ажиллаж байна. АПУ компани олон нийтийн хог хаягдлын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, ангилах, дахин боловсруулах дадал, тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд “Өнгө нэм” ТББ-ын зохион байгуулж буй “Дахин боловсруулцгаая- Go Recycle” аянтай урт хугацаанд хамтран ажиллахаар боллоо. Ингэснээр НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 3, 11, 12, 13 дахь зорилтыг биелүүлэхэд хувь нэмэр оруулж, байгаль нийгэм, эдийн засаг, ирээдүйд ээлтэй хандлага, дадал, тогтолцоог бий болгохоор зорин ажиллаж байна.





НИЙГЭМ

**ШИЛДЭГ ИННОВАЦИЛАГ ТӨСЛИЙН ХАМТРАГЧ АРХАНГАЙ АЙМГИЙН ЧУЛУУТ СУМЫН МАЛЧДАД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЛЭЭ**

АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр - Архангай аймгийн Чулуут суманд 2022 оноос “Монгол Сарлаг” төслийг хэрэгжүүлж, малчидтай хамтран бүтээсэн Mont Yak брэндийг зах зээлд нийлүүлээд байгаа билээ. Тус сумын 80 хувьд өвөлжилтийн нөхцөл хүндэрч зудын байдал үүссэн. Иймд АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэрийн хамт олон Архангай аймгийн Чулуут сумын 100 гаруй малчдад өвс, тэжээлийн тусламж хандив үзүүлээ. Мөн анхны малчидтай хамтарсан орон нутагт нэмүү өртөг шингээн ажилласан Монгол сарлаг төсөл нь “BEST INNOVATION FOR CORPORATE SOCIAL RESPONSIBILITY” сертификат буюу компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн шилдэг инновацлаг төслөр шалгарсан юм.



**“ГАЙХАМШИГТ ЖОЛООЧ – УУСАН БОЛ ЖОЛОО БАРЬДАГГҮЙ” НИЙГМИЙН ЭЭРЭГ НӨЛӨӨЛЛИЙН АЯНЫ САЙН ТУРШЛАГАА ХУВААЛЦЛАА**

“Соёлоор гоёно” төслийн дэд хэсэг болох “Гайхамшигт жолооч - Уусан бол жолоо барьдаггүй” аяныг 2023 оноос хэрэгжүүлж хариуцлагатай, зохистой хэрэглээг уриалан компани ажлыг шат дараатайгаар өрнүүлэн ажиллаж буй билээ. Уг төслийг олон улсын зан төлөвийн судалгаанд суурилан амлалт өгөх аргачлалаар, зөв зохистой, хариуцлагатай хэрэглээний соёлыг түгээх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бүтээгдэхүүний инновацтай хослуулан хэрэгжүүлж буй бөгөөд нийгэмдээ эергээр нөлөөлж буй сайн туршлагаа хуваалцаж, “Social impact 2024” үйл ажиллагаанд хамтран ажиллалаа. Энэхүү аяны хүрээнд согтуугаар тээврийн хэрэгсэл барих зөрчлийн тоо 20 гаруй хувиар буурсан төдийгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх амлалтаа 10 мянга гаруй жолооч өгсөн байна. Нийгмийн эерэг нөлөөллийн энэхүү аяныг олон нийт эерэгээр хүлээн авч “Мөнгөн Мод 2023” наадмаас Зар сурталчилгааны шилдэг бүтээл шагнал хүртсэн юм.



## ХҮН - МЕНЕЖМЕНТ

### МАНЛАЙЛАХ УР ЧАДВАРТ ХӨТЛӨХ НЬ

Манлайлах ур чадварын хүрээнд баг удирддаг ажилтны зайлшгүй мэдсэн байх ёстой ойлголтуудыг цогц хэлбэрээр багтаасан хөтөлбөр бөгөөд баг хамт олноо эерэг уур амьсгалтай, бүтээлч сэтгэлгээтэйгээр удирдан манлайлж, оновчтой шийдвэр гаргахад нөлөөлөх олон ур чадварыг нэг дор эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ORP Institute of Korea /Korean and Mongolian Consultants/ институттэй хамтран компанийн чиг үүрэг бүрийн ажилтнуудаас багш нараа бүрдүүлэн сургалтад хамруулан бэлтгэж уг төслийг амжилттайгаар хэрэгжүүлсээр байна.



### BOOSTIPAY

Хүний нөөцийн бүрдүүлэлтийг дэмжин, алба хоорондын ажлын урсгалыг оновчлон, удирдлага нь ажил эрхлэлтийн гүйцэтгэлийн үнэлгээг оруулж, мэдээллийн санг үүсгэх боломжтой болж, сонгон шалгаруулалтын системтэй холбогдсоноор ажилтны мэдээлэл шууд татагдах боломжийг бүрдүүлснээс гадна “Corporate gateway” системээр дамжуулан ажилтны цалинг өдөр тутамдаа цаг алдалгүй цалингийн шилжүүлэг хийгддэг боллоо.

АПУ ХК-ийн хүний нөөцтэй холбогддог бүхий л үйл ажиллагаа цахимжиж, бүтээмжийг үнэлэх, цаг бүртгэлийг хялбар болгох, гар ажиллагааг бууруулах, нэгдсэн дата системээр хянах, эргэх холбоо бий болгох, хөдөлмөрийн харилцаанд шаардагдах баримт материалыг автоматжуулах зэргээр маш олон талбарт цахим шийдлүүд нэвтрүүлээд байна.



### ASK CHATBOT 2.0

Хэрэгцээт мэдээллээ хэзээ ч, хаанаас ч авах боломжийг бүрдүүлэн ажлын шинэ эринд нэгдэх зорилгоор Ask Chatbot 2.0-г хөгжүүлэн хэрэглэнд нэвтрүүллээ. Үүнийг ашигласнаар ажилтан бүр өөрт хэрэгцээтэй бүхий л мэдээллээ энэ системээр хурдан хялбар авах боломжтой болж, цаг хугацаа хэмнэн аливаа асуудлыг хялбар шийдэх, бүтээмжийн хурд сайжирч байна.





## СОЁЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

### “ХАМАГ МОНГОЛ – ДЭЛХИЙД” СОЁЛЫН ФЕСТИВАЛИЙГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Уламжлал болгон зохион явуулдаг “Хамаг Монгол” соёлын фестивалийг түүхэн 100 жилийн ойдоо зориулан брэнд бүтээгдэхүүнээ экспортлогч болон хамтын ажиллагаатай улсуудын соёлыг түгээх агуулган дор “Хамаг Монгол - Дэлхийд” сэдэвтэйгээр амжилттай зохион байгууллаа. Нийт ажилчдынхаа хамтын нөхөрлөл, нэгдлийг бий болгох, халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх зорилготой “Хамаг Монгол” урлагийн наадамд нийт найман багийн 2400 гаруй залуус авьяас чадвар, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.



### ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ӨНГӨ

Үндэсний спортын АПУ ХК-ийн тамирчдад үзүүр, түрүү, айрагтай сайхан наадлаа. Тулгар төрийн 2233, Их Монгол Улс байгуулагдсаны 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Үндэсний их баяр наадамд Монгол улсын арслан Б.Орхонбаяр Хүчит бөхийн барилдаанд үзүүрлэж, Монгол улсын тод манлай уяач О.Батбилэг Их нас, Соёолон насанд тус тус хурдан морио айрагдууллаа. Мөн түүнчлэн үндэсний харваа, шагайн харваан спортын тамирчид амжилт дүүрэн наадлаа.



### “ДЭЭЛТЭЙ МОНГОЛ 2024” НААДАМ

Монгол түмний өв соёл, уламжлал, язгуур хэв маягийг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Дээлтэй Монгол 2024” наадмын баярын жагсаалд АПУ ХК-ийн хамт олон Монгол өв “Соёлоор гоёж” үндэстэн ястны дээл хувцас, ардын ёс заншлаа таниулан сурталчиллаа.



СПОРТ

**ДЭЛХИЙН АВАРГЫН ЦОМ МОНГОЛД**


Анхны Дэлхийн аваргын цом, Роналдогийн Алтан бөмбөг, Марадонагийн Дэлхийн аваргын алтан медаль, Пелегийн Дэлхийн аваргад өмсөж байсан өмсгөл зэрэг үнэт үзмэрүүдийг спортыг дэмжигч АПУ компани, Нийслэл брэнд болон ФС Улаанбаатар хамтран хөл бөмбөгийн спортод сонирхолтой, хайртай дэмжигч нартаа зориулан эдгээр түүхэн гайхамшигт үзвэрүүдийг эх орондоо авчрах ажлыг зохион байгууллаа.



**"EURO 2024", "PARIS OLYMPICS 2024" АЛБАН ЁСНЫ ЭРХТЭЙГЭЭР ШУУД ДАМЖУУЛЖ БАЙНА**

АПУ компани Централ телевизтэй хамтран "UEFA EURO -2024" буюу Европын хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг шууд дамжуулан үзүүллээ. Спортын арга хэмжээг үргэлж дэмжин ажиллаж ирсэн төдийгүй спортод хайртай үнэнч хөгжөөн дэмжигч, хэрэглэгч, харилцагч нартаа 100 жилийн баяраа тохиолдуулан бэлэг барьж байна.

Мөн хүн төрөлхтний эв нэгдлийн бэлэг тэмдэг болсон Францын Парис хотноо болох 33-р зуны олимпын наадам "Paris Olympics 2024", "Paris 2024 Paralympics" наадмыг тус тус албан ёсны эрхтэйгээр шууд дамжуулан хүргэх гэж байна.





APU COMPANY

Төгс. Төгөлдөр. Тунгалаг.



АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот - 17040, Чингисийн өргөн чөлөө - 14,

Утас: +976 - 7600 2220, Факс: +976 - 11 - 343063

[www.apu.mn](http://www.apu.mn)















Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

АПУ ХК-ийн 2024 оны эхний хагас жил

<u>Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/</u>			
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>			
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ УБГД: 000165753, РД: 2702673 ҮЦКод: АПУ Утас: 11-344336		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Шингэн хүнсний үйлдвэрлэл		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тооширхэг	1,064,181,553		
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Санхүү, тайлагналын албаны дарга Ж.Оюумаа, Комплайнсын мэргэжилтэн Б.Мягмар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан		
I.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтүүдийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгө	448,952,351,817	516,443,421,474
	Эргэлтийн бус хөрөнгө	569,528,947,000	553,987,106,615
	<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,018,481,298,817</b>	<b>1,070,430,528,089</b>
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	157,674,499,117	120,713,060,250
	Урт хугацаат өр төлбөр	180,231,143,387	207,909,629,078
	Эздийн өмч	680,575,656,313	741,807,838,760
	<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>1,018,481,298,817</b>	<b>1,070,430,528,089</b>
Орлогын тайлан	<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
	Борлуулалтын орлого (цэвэр)	1,105,352,126,000	649,401,733,505
	Борлуулалтын өртөг	(625,950,191,183)	(336,965,178,245)
	Нийт ашиг ( алдагдал)	479,401,934,817	312,436,555,260
	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>157,663,407,644</b>	<b>139,642,348,969</b>
	Орлогын татварын зардал	(40,605,307,000)	(31,743,136,948)
	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>117,058,100,644</b>	<b>107,899,212,021</b>
	Бусад дэлгэрэнгүй орлого	1,853,596,000	156,958,758
	<b>Нийт орлогын дүн</b>	<b>118,911,696,644</b>	<b>108,056,170,780</b>
	Толгой компанийн хувьцаа эзэмшигчэд ноогдох	146,794,558,644	120,954,597,763
	Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	(29,736,458,000)	(13,055,385,742)

		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	Өмч	106,418,200	106,418,200
		Халаасны хувьцаа	-	-
		Нэмж төлөгдсөн капитал	226,646,951,296	226,646,951,296
		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	157,839,025,854	157,545,846,361
		Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(56,565,000)	100,393,758
		Хуримтлагдсан ашиг	274,269,754,963	348,693,543,887
		<b>Нийт эздийн өмчийн дүн</b>	<b>658,805,585,313</b>	<b>733,093,153,502</b>
		Хяналтын бус хувь оролцоо	21,770,071,000	8,714,685,258
		<b>Нийт дүн</b>	<b>680,575,656,313</b>	<b>741,807,838,760</b>
		<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	184,382,607,000	158,389,065,141
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(117,469,073,000)	(58,204,767,364)
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,853,189,000	(72,674,123,719)
		<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>85,766,723,000</b>	<b>27,510,174,058</b>
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	38,365,142,000	122,152,149,000
		Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт болон валютын ханшийн өөрчлөлт	(1,979,716,000)	747,138,424
		<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>122,152,149,000</b>	<b>150,409,461,482</b>
2.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>			
	АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 08 сарын 01-ний өдрийн ээлжит хурлаар АПУ Групп компанийн 2024 оны 1 дүгээр хагас жилийн тайланг хэлэлцэн батална.			
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>			
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	<b>Харьцаанууд</b>	<b>2023</b>	<b>2024Q2</b>
		Нийт ашгийн хувь	43%	48%
		Үйл ажиллагааны ашгийн хувь	14%	22%
		Цэвэр ашгийн хувь	11%	17%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	18%	15%
		Нэгж хувьцаанд ногдох ашиг	137,941.22	113,659.69
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	<b>Харьцаанууд</b>	<b>2023</b>	<b>2024Q2</b>
		Эргэлтийн харьцаа	2.85	4.28
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	1.27	1.99
		Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.50	0.44
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Инфляци болон гадаад валютын ханшийн өсөлт, нийлүүлэлтийн гинжин сүлжээний үнийн өсөлтөөс хамаарч түүхий эд материалын үнэ өсч улмаар бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ өсөхөд шууд нөлөөлж байна. Үүний эсрэг ажлын капиталын удирдлага болон санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах замаар хариу арга хэмжээ авч ажиллаж байна.		
3.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>	Байхгүй		
4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>			

	<ul style="list-style-type: none"> <li>- Их хэмжээний хэлцэл тухайн тайлант хугацаанд гараагүй</li> <li>- Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээг жилийн эцсийн тайлангаар толилуулна (2023 оны жилийн эцсийн тайлангийн тодруулгад тусгасан байнгын шинжтэй сонирхлын зөрчилтэй хэлцлээс өөр хэлцэл хийгдээгүй болно).</li> </ul>								
5.	<p><i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i></p> <p>Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.</p>								
6.	<p><i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i></p> <p style="text-align: center;"><b>Хувьцаа эзэмшигчдийн хурал</b></p> <p>Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2024 оны 04 сарын 30-ны өдрийн 14:00 – 15:30 цагийн хооронд 88.08%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. АПУ ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2023 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг батлав.</li> <li>2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.</li> <li>3. АПУ ХК-ийн ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар сонгов:       <ol style="list-style-type: none"> <li>1. Пүрэвийн Батсайхан</li> <li>2. Бүрэнтогтохын Батбаяр</li> <li>3. Кеннет Чу</li> <li>4. Сэн И-Ин</li> <li>5. Батсайханы Гантиг</li> <li>6. Баярцогтын Гомбо-Эрдэнэ</li> </ol> <p>Хараат бус гишүүн</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун</li> <li>2. Одончимэдийн Одбаяр</li> <li>3. Жигжидийн Үнэнбат</li> </ol> </li> <li>4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар батлав.</li> </ol> <p style="text-align: center;"><b>Төлөөлөн удирдах зөвлөл</b></p> <p>ТУЗ-ийн гишүүн Сергей Громов, Доржийн Миеэгомбо нар чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар ТУЗ-ийн дараах бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаатай сонгов.</p> <p><b>ТУЗ-ийн бүрэлдэхүүн:</b></p> <table border="0"> <tr> <td> <p>ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга <b>ПҮРЭВИЙН БАТСАЙХАН (Инженер мэргэжилтэй)</b> Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч 2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга Хувьцаа эзэмшил: 0.01%</p> </td> <td></td> </tr> <tr> <td> <p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР (Эдийн засагч мэргэжилтэй)</b> Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.01%</p> </td> <td></td> </tr> <tr> <td> <p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>КЕННЕТ ЧУ (Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй)</b> Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал 2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p> </td> <td></td> </tr> <tr> <td> <p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>СЭН И-ИН (Хуульч мэргэжилтэй)</b> Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал 2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p> </td> <td></td> </tr> </table>	<p>ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга <b>ПҮРЭВИЙН БАТСАЙХАН (Инженер мэргэжилтэй)</b> Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч 2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга Хувьцаа эзэмшил: 0.01%</p>		<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР (Эдийн засагч мэргэжилтэй)</b> Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.01%</p>		<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>КЕННЕТ ЧУ (Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй)</b> Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал 2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p>		<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>СЭН И-ИН (Хуульч мэргэжилтэй)</b> Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал 2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
<p>ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга <b>ПҮРЭВИЙН БАТСАЙХАН (Инженер мэргэжилтэй)</b> Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч 2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга Хувьцаа эзэмшил: 0.01%</p>									
<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР (Эдийн засагч мэргэжилтэй)</b> Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.01%</p>									
<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>КЕННЕТ ЧУ (Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй)</b> Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал 2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p>									
<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>СЭН И-ИН (Хуульч мэргэжилтэй)</b> Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал 2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p>									

	<p>ТУЗ-ийн ердийн гишүүн  <b>БАТСАЙХАНЫ ГАНТИГ</b> (Бизнесийн удирдлага, менежмент мэргэжилтэй)  Дижитал концепт ХХК-ийн Гүйцэтгэх захирал  2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
	<p>ТУЗ-ийн ердийн гишүүн  <b>БАЯРЦОГТЫН ГОМБО-ЭРДЭНЭ</b> (Хэрэглээний математикч, эдийн засагч, санхүүч мэргэжилтэй)  Шунхлай холдинг ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал  2024 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
	<p>ТУЗ-ийн хараат бус гишүүн  <b>ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН</b> (Эдийн засагч мэргэжилтэй)  Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч  2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
	<p>ТУЗ-ийн хараат бус гишүүн  <b>ОДОНЧИМЭДИЙН ОДБАЯР</b> (Багш, эрх зүйч мэргэжилтэй)  Ард даатгал ХК, Ард холдинг ХХК, Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн гишүүн  2021 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
	<p>ТУЗ-ийн хараат бус гишүүн  <b>ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ</b> (Эдийн засагч мэргэжилтэй)  2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
<p style="text-align: center;"><b>Гүйцэтгэх удирдлагын баг</b></p> <p>Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын багийг удирдан ажилладаг. 2024 оноос стратеги эрхэлсэн захирал Б.Гантиг гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөж, ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон.</p>		
<p style="text-align: center;"><b>Гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн:</b></p>		
	<p>Гүйцэтгэх захирал  <b>ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ</b>  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
	<p>Санхүү эрхэлсэн захирал, Төслийн удирдлагын захирал  <b>ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ</b>  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
	<p>Экспорт эрхэлсэн захирал  <b>АРИУНА ДАНДАРОВА</b>  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
	<p>Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал  <b>НИКОЛАЙ ДОБРЕВ</b>  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
	<p>Борлуулалт, маркетинг эрхэлсэн захирал  <b>БАТСАЙХАНЫ ЦАЦРАЛ</b>  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
	<p>Захиргаа, хүний нөөц эрхэлсэн захирал  <b>ЖАРГАЛСАЙХАНЫ ИЧИНХОРЛОО</b>  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
	<p>АПУ Дэйри ХХК-ийн Гүйцэтгэх захирал  <b>ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ</b>  Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
<p style="text-align: center;"><b>Бусад эрх бүхий албан тушаалтан</b></p> <p>Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс гадна ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч нь компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно. Тайлант хугацаанд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Чадраабалын Ариунсан (хувьцаа эзэмшил 0.00%), Ерөнхий нягтлан бодогчоор Батсуурийн Даваадорж (хувьцаа эзэмшил 0.00%) ажиллав.</p>		



**АПУ Групп компанийн бүтэц**  
 Тайлант хугацаанд АПУ Групп компанийн бүтцэд өөрчлөлт гараагүй.  
**Хувьцаа эзэмшигчдийн бүтэц**  
 АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчид (2024 оны 04 сарын 12-ны өдрийн байдлаар)

Д/д	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
1	ШУНХЛАЙ ХОЛДИНГ ХХК	596,286,011	56.03
2	HEINEKEN ASIA PACIFIC PTE LTD	266,091,981	25.00
3	STEPPE BEVERAGE KFT	60,071,826	5.64
4	Бусад	141,731,735	13.32

Өнгөрөгч оны мөн үетэй харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Steppe Beverage KFT-ийн эзэмшлийн хувь 5%-аар буурч, бусад жижиг хувьцаа эзэмшигчдэд шилжжээ.

**Ногдол ашгийн мэдээлэл**

ТУЗ-ийн 2024 оны 02 сарын 16-ны өдрийн 24/02 тоот тогтоолоор 2023 оны хоёрдугаар хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан нэгж хувьцаанд ₮44 (дөчин дөрвөн төгрөг)-ийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэн, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр (2024 оны 04 сарын 12-ны өдөр)-өөр тогтоож, ногдол ашгийг 2024 оны 12 сарын 31-ний өдрийн дотор төлөхөөр тогтоов. Тус ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан ба таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгов.

**Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт**

АПУ ХК-ийн 2023 оны эцсийн компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайлангаар нийт 72 онооноос 70 оноо буюу 97%-аар үнэлснийг СЗХ-ны компанийн засаглал, комплайнсын хэлтсээс хянан баталгаажуулж, 67 оноо буюу 93%-аар үнэлснээр “засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдлээ. Ийнхүү АПУ ХК нь кодексийн хэрэгжилтийн хянан баталгаажуулсан үнэлгээгээр нээлттэй хувьцаат компаниудаас 4-р байранд эрэмбэлэгдэж байна.

**Хувьцааны арилжааны мэдээлэл**

АПУ ХК-ийн хувьцааны хаалтын ханш оны эхэнд ₮1,201 байсан бол хагас жилийн эцэст ₮984 болж буурсан. Зах зээлийн үнэлгээ 2024 оны эхний хагас жилийн эцэст 1.05 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 23%-аар буурсан байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Эрдэнэбилэг

Албан тушаал: “АПУ” ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ч.Ариунсан -

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: .....